

ЯМААНЫ ГОДРОН /Ямааны уушгины хавьтал халдварт үрэвсэл/ ӨВЧНӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ ЗААВАР
(А-08, ССРР- Contagious caprine plueropneumonia)

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

1.1. Зорилго: Ямааны годрон өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтой, шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино. Энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-ийн, уг өвчинтэй тэмцэх арга хэмжээг мөн хуулийн 4.1.7-ийн дагуу хэрэгжүүлнэ.

1.2. Хамрах хүрээ: Уг өвчнөөр тайван бус болон өвчин тархах эрсдэлтэй хот айл, аж ахуй бүхий бүс нутагт энэ өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг энэхүү зааврын дагуу хэрэгжүүлнэ. Зааврыг мал эмнэлгийн бүх шатны байгууллага, малын эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан, мал эмнэлгийн улсын байцаагч, малчин, мал өмчлөгч, мал бүхий иргэд, иргэн, хуулийн этгээд, орон нутгийн засаг, захиргааны удирдлага дагаж мөрдөнө.

1.3. Өвчний тодорхойлолт: Халуурах, ханиах, цээжний хөндийн гялтан үрэвсэх, уушгинд үхжил үүсэх шинж тэмдгээр илэрдэг хавьтал халдварт өвчин юм.

1.4. Үүсгэгч, үүсгэгчийн тэсвэрт чанар: Ямааны годрон өвчин нь *Mycoplasma capricolum* дэд зүйл *capripneumoniae* (Мсср) зүйлийн микоплазмаар үүсгэгдэнэ. Бага хэмд тэсвэртэй бөгөөд цельсийн хасах 10 – 12⁰С – д 50 хоног, 0⁰С -д хэдэн сар амьдрах чадвараа хадгална. Халаахад амархан үхнэ. Цельсийн нэмэх 56⁰- 60⁰С-д 40 минутад идэвхгүйжнэ. Цээжний хөндийн хөлдөөсөн шингэнд 10 жил амьд байна. Халдваргүйжүүлэх бодисын үйлчлэлд идэвхээ амархан алдана.

1.5. Өвчний тархвар зүйн онцлог: Годронгоор ямаа улирлын хамааралгүй өвчилнө. Мөн янгир ямаа, бор гөрөөс, зээр өвчилнө. Зориуд халдаасан хонь өвчилдөг боловч үхэх нь ховор бөгөөд цаашид уг өвчнийг дамжуулагч болно. Өвчин гарсан суурийн ямаа бараг толгой дараалан өвчилж үхэл 80-90 %-д хүрдэг. Ердийн нөхцөлд халдвар агаар дуслын замаар дамжина. Бэлчээр, ус нэгтэй газарт халдвар богино хугацаанд сүрэгт тархана. Мал ядарч доройтох, тэжээлээр дутагдах, хол тууварлагдах болон бог малын мялзан төст өвчин, маеди-висна, цэцгийн вирусээр халдварлагдсан тохиолдолд хоёрдогч халдварын хэлбэрээр хавсран өвчилж болно.

1.6. Халдварын эх үүсвэр, халдвар дамжих зам: Ердийн нөхцөлд хавьтал, агаар дуслын замаар халдварлана. Нялх ишиг бага мэдрэмтгий байх ба 5-6 сарын настайгаас эхлэн хүндээр өвчилнө. Өвчилж өнгөрсөн ямаа мөн зарим төрлийн зэрлэг амьтад болох зээр, янгир, бор гөрөөс зэрэг амьтад нь уг өвчний үүсгэгчийг удаан хугацаанд тээж, халдвар тараах эрсдэл бий болно.

1.7. Эмнэл зүйн шинж тэмдэг: Өвчний нууц үе нь 3-10 хоног, зарим үед 45 хоног хүртэл байна. Өвчний явц нь хурц болон архаг гэсэн 2 үндсэн хэлбэртэй байна. Голомтын бус нутгийн эрүүл ямаан сүрэгт халдвар хурц, голомттой нутагт ихэвчлэн архаг хэлбэрээр илэрнэ. Хурц хэлбэрийн өвчлөл дунджаар 12-16 цагийн дундаж хугацаанд үргэлжилж, уушгины элэгшилт эрчимтэй явагдсанаас үүдэн өвчилсөн ямаа богино хугацаанд үхнэ. Өвчилсөн ямааны биеийн ерөнхий байдал богино хугацаанд муудаж, сүргээсээ хоцрох, хуурай ханиалгах, биеийн халуун 42⁰С хүрч халуурах,

тэжээл усанд дургүй болох, хивэхгүй байх, толгойгоо гудайлгаж сүүлээ унжуулан хөлөө солбин эвхийж хөдөлгөөнгүй зогсох, амнаас хөөстэй шүлс, хамраас салс, идээт шингэн гоожих шинж тэмдэг ажиглагдана. Тасалдсан, уухичсан амьсгалтай болно. Хавирганы завсраар дарахад маш хөндүүр, чагнахад хэржигнүүртэй байх ба тогшиход уушгины дотор хязгаарын зарим хэсэгт битүү чимээ сонсогдоно. Хамрын шингэн гоождос хуралдсаар хамрын нүхийг нарийсгаж, бөглөснөөс улбаалан бие махбодид хүчилтөрөгчийн дутагдал үүсч, үхдэг талаар хэвлэлд тэмдэглэжээ. Годрон өвчин байнга гардаг нутагт архаг, ужиг хэлбэрээр гарч өвчний эмнэл зүйн шинж тэмдэг бүдэг илэрч, ямаа хааяа ханиалгах, турах, салст бүрхүүлүүд цайх, хөнгөн халуурах шинж тэмдэг илэрнэ.

1.8. Бие бүтцийн эмгэг хувирал: Гол өөрчлөлт нь амьсгалын эрхтэнд явагдаж, ялангуяа уушгинд илрэх бөгөөд уушгины гэмтсэн хэлтэр томорч хатуурна. Энэ эмгэг ихэвчлэн нэг талын уушгинд тохиолдох ба нөгөө талын хэлтэр цусаар дүүрэн элэг мэт хүрээтсэн байна. Уушгийг хөндлөн зүсэж үзэхэд янз бүрийн өнгөтэй, жижиг мөхлөгт гадаргуутай байх боловч хэлтэр хоорондын хэсгүүд нь зузаараагүй байна. Ихэнх тохиолдолд цээжний гялтан үрэвсэж, хөндийд нь шүүрлийн шингэн ихээр хуримтлагдан, заримдаа уушгийг бүхэлд нь бүрхэнэ. Цочмог явцтай үед цээжний хөндийд ширхэгэнцэр бүхий их хэмжээний шингэн хуримтлагдана. Ужиг явцтай үед уушгины эд харлах, үхжих, уушги гялтангийн хооронд зузаан наалдац үүсэх үйл явц элбэг тохиолдоно. Заримдаа уушгины цээжний хөндийн гялтан хальстай наалдалт үүссэн байж болно

ХОЁР.ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

2.1. Оношилгоо: Өвчний тархвар зүйн онцлог, өвчилсөн малд илрэх эмнэлзүйн шинж тэмдэг, бие бүтцийн эмгэг хувиралд үндэслэн анхны онош тавина. Өвчний сэжигтэй тохиолдолд Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээнд зориулан дээж авах, бэлтгэх, хадгалах, илгээх холбогдох журмын дагуу дээж авч лабораторид хүргүүлэн өвчний оношийг баталгаажуулна. Шинжилгээнд цусны ийлдэс, уушгины эмгэгтэй хэсгийн дээж, цээжний хөндийн шингэн, хамрын гоождос зэргийг авна. Уушгины сорьц авахдаа уушгины эмгэгт өөрчлөлттэй хэсгийг эрүүл хэсэгтэй тэнцүү хэмжээтэй байхаар буюу заагийг голлуулан зүсэлт хийж авна

2.2. Лабораторийн оношилгоо: Лабораторид ирүүлсэн дээжид нян судлал, молекул биологи, ийлдэс судлалын шинжилгээг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын “Газрын амьтны халдварт өвчнийг оношлох гарын авлага”-д заасны дагуу гүйцэтгэн оношийг баталгаажуулна.

2.3. Ялгаварлан оношлох: Цусан халдвар, сүрьеэ, бог малын мялзан, маеди-висна, сохор догол, сахуулайт үрэвсэл зэрэг өвчнөөс ялгаварлан оношилно.

2.4. Эмчилгээ: Годронгоор өвчилсөн ямааг эмчлэх арга боловсрогдоогүй байна.

ГУРАВ. ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ:

3.1. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох

3.1.1. Ямааны годрон өвчин нь хорио цээрийн дэглэм тогтоож тэмцэх өвчний ангилалд хамаарна. Өвчний онош тогтоогдож лабораторийн шинжилгээгээр баталгаажсан хот айл, ямааны аж ахуй, бүс нутагт хорио цээрийн дэглэм тогтоож өвчинтэй тэмцэх арга хэмжээг хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үеийн холбогдох журам болон энэхүү заавар, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн баримт бичгийг баримтлан хэрэгжүүлнэ.

3.1.2. Хорио цээрийн дэглэмийн үед голомтын бүсийн хилийн заагийг халдварын явц, болон тухайн газар нутгийн байгалийн онцлогийг харгалзан үзэж тойрог хэлбэрээр тогтооно.

3.1.3. Өвчний голомтод ажиллаж байгаа малын эмч тархвар зүйн судалгаа хийж өвчний эмнэлзүйн шинж тэмдэг, бие бүтцийн эмгэг өөрчлөлтүүдийг баримтжуулж, гүйцэтгэсэн ажлын тэмдэглэл өдөр бүр хөтөлнө.

3.1.4. Голомтод байгаа малчдад ямааны годрон өвчин, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулж, зөвлөгөө өгнө.

3.1.5. Хорио цээрийн дэглэм тогтоосон газар нутгийн хил хязгаар, өвчний голомт болон голомтод байгаа хот айл, ямааны аж ахуйн байршил, халдваргүйтгэлийн болон хорио цээрийн нэвтрэн өнгөрүүлэх цэг, шилжилт, хөдөлгөөний гол зам зэргийг багтаасан тархварзүйн зураглал үйлдэнэ.

3.1.6. Хорио цээрийн дэглэм тогтоосон халдварын голомтын бүс, сэжигтэй бүс, хамгаалалтын бүс нутгаас мал шилжүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэхийг болон хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутгийн өвчтэй малын сүү, мах, арьс, шир ашиглахыг дэглэм үргэлжлэх хугацаанд хориглоно.

3.1.7. Өвчтэй малын бууц, баас, тэжээлийн үлдэгдлийг шатаах болон биотермийн аргаар, харин малын хашаа, байр, ус, тэжээлийн онгоц, тоног хэрэгслийг нь 0,05%-ийн формальдегид, 0,01%-ийн мөнгөн усны хлорид, 1%-ийн фенол, 1%-ийн натрийн гипохлорит, 70% этилийн спирт, фенолын ариутгагч бодис, иодофор, формальдегид, глутаральдегид, перацетитын хүчил зэргийг агуулсан халдваргүйтгэлийн бэлдмэлээр халдваргүйтгэнэ. Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн холбогдох зааврыг баримтлан халдваргүйтгэлийг хэрэгжүүлнэ.

3.1.8. Хорио цээрийн дэглэмийг сүүлчийн өвчилсөн ямаа үхсэн, устгаснаас хойш 45 хоногийн хугацаанд дахин ямаа өвчлөөгүй бол голомтын бүс нутгийн ямаанд (хонь) эмнэл зүйн үзлэг хийж, өвчний шинж тэмдэг илрэхгүй бол өвчтэй мал, амьтанд хэрэглэж байсан тоног хэрэгсэл, хашаа, байр, хэвтэр бууц, усны болон тэжээлийн онгоц зэрэгт төгсгөлийн халдваргүйтгэл хийж, мал эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хорио цээрийн дэглэм тогтоосон албан тушаалтны шийдвэрээр дэглэм бууруулж, хязгаарлалтын 14 хоногийн дэглэмд шилжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хязгаарлалтын дэглэмийг хэдэн ч удаа сунгаж болно.

3.2. Ямааг зориудаар устгах арга хэмжээ

3.2.1. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дах заалт, Газрын амьтны эрүүл мэндийн кодексын 14 дүгээр зүйлийн 3.2 дах хэсэгт заасны дагуу Монгол улсын ерөнхий малын эмчийн шийдвэрээр ямааны годрон өвчний дэгдэлтийг дарах шаардлагаар голомтод байгаа бүх өвчлөмтгий(Ямаа) малыг өвчтэй, эрүүл гэж ялгахгүйгээр сүргээр нь зориуд устгаж болно.

3.2.2. Зориудаар устгасан ямаа болон тэдгээрийн гаралтай түүхий эд, үхсэн малын хүүр, сэг зэмийг холбогдох эрх зүйн акт, журмын дагуу устгана.

2.2.3. Халдварын голомтод зайлшгүй шаардлагаар устгасан ямааны нөхөн төлбөрийг хуульд заасны дагуу мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

3.2.4. Газрын амьтны эрүүл мэндийн кодексын 14.3.2-т зааснаар ямааны годрон өвчнөөр хамгийн сүүлд өвчилсөн малыг устгаснаас хойш нэг жил өнгөрч, дахин шинэ халдвар илрээгүй бол ямааны годрон өвчнөөр тайван гэж үзнэ

3.2.5. Хэрэв дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын газрын амьтны эрүүл мэндийн кодексын 14.3 дугаар бүлэгт өөрчлөлт орсон тохиолдолд шинэчлэгдсэн хувилбарыг дагаж мөрдөнө.

3.3.Тандалт

3.3.1. МЭЕГ-ын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ямааны годрон өвчний тандах төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын дотор батлах ба батлагдсан төлөвлөгөөг аймаг, сум, дүүргийн мал эмнэлгийн сүлжээ лаборатори, сум, дүүргийн тасаг хамтран хэрэгжүүлнэ.

3.3.2. Мал эмнэлгийн бүх шатны байгууллага хөрш улс, аймаг, сумаас өвчин нэвтэрч болох эрсдэлийн үнэлгээг тогтмол явуулж, дамжин нэвтрэх боломжит замуудыг хяналтад авах, биет болон газар зүйн хориг саадыг ашиглан эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна.

3.3.3. Ямааны годрон өвчнийг аль болох эрт илрүүлэх, өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэхийн тулд тандалтыг тархвар зүйн аргачлалын дагуу мэргэжлийн баг жил бүр тодорхой хугацаанд хийж, үр дүнг харьяалах дээд шатны мал эмнэлгийн байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

3.4. Импортын мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

3.4.1. Өвчнөөр тайван болон тайван бус орноос амьд мал, амьтан, тэдгээрийн гаралтай эд бүтээгдэхүүн импортлох тохиолдолд (ДМАЭМБ)-ын “Газрын амьтны эрүүл мэндийн кодекс”-ын 14.3 –д заасан зөвлөмжийг үндэслэн экспортлогч болон импортлогч орнуудын мал эмнэлгийн эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох, импортлох үеийн олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний шаардлага буюу мал эмнэлэг, хорио цээр, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг мөрдөн хэрэгжүүлнэ.

3.2.2. Импортлохын өмнө экспортлогч орны ямааны годрон өвчний гаралт, тархалтын байдалд МЭЕГ-аас хийсэн эрсдэлийн дүн шинжилгээ, үнэлгээнд тулгуурлан импортын

зөвшөөрөл олгоно. Импортоор оруулж ирсэн ямааг 45-аас багагүй хоногийн хугацаанд хорио цээрийн хяналтад байлгаж шинжилгээнд хамруулна.

3.5. Дотоодын мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

3.5.1. Ямааны годрон өвчний хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм цуцлагдсанаас хойш халдвар бүртгэгдэж байсан бүс, нутгаас хонь, ямааг үржил, отор нүүдэл, хэрэгцээлэх зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх тохиолдолд тээвэрлэхийн өмнөх 45-аас доошгүй хоног болон тээвэрлэх өдрийн байдлаар ямааны годрон өвчний тохиолдол албан ёсоор бүртгэгдээгүй, тухайн бүс нутагт годрон өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй болохыг баталгаажуулсан мал эмнэлгийн гэрчилгээг авна.

3.5.2. Ямааны гаралтай түүхий эд, мах, бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх тохиолдолд тээвэрлэхийн өмнөх 45-аас доошгүй хоног болон тээвэрлэх өдрийн байдлаар ямааны годрон өвчний тохиолдол албан ёсоор бүртгэгдээгүй, тухайн бүс нутагт годрон өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй, төхөөрөлтийн дараах мал эмнэлгийн хяналтын үзлэг, шинжилгээгээр ямааны годрон өвчний үед илэрдэг эмгэг өөрчлөлтгүй ямааны мах болохыг баталгаажуулсан мал эмнэлгийн гэрчилгээг авна

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

4.1. Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлгийн байгууллага ямааны годрон өвчний илрэх шинж тэмдэг, халдвар дамжих зам, ямааны годрон өвчний эрсдэл болон түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар мэдээлэл, гарын авлага бэлтгэж малын эмч, мал эмнэлгийн техникийн ажилтан, мал эмнэлгийн улсын байцаагч, малчид, мал өмчлөгчдөд түгээх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангана.

4.2. Малчин, мал, амьтан маллагч хот айл, аж ахуйд уг өвчний сэжиг, шинж тэмдэг ажиглагдсан даруйд харьяалах мал эмнэлгийн байгууллагад 12 цагийн дотор мэдэгдэнэ.

4.3. Хот айл, ямааны аж ахуй эрхлэгчид мал маллах, тээвэрлэхдээ малын хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдох журам, зааврыг мөрдөнө.

4.4. Өвчтэй болон эрүүл ямаа, хонийг нэг хашаанд байлгах, хамт хариулах, бэлчээр, хэвтэр бууц, тэжээл, ус, хужрын онгоц нэгтэй байлгах, халдвартай малыг эрүүл бүсэд авчрах, сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн хяналт, зөвшөөрөлгүй отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийх, өвчний халдвар авсан ямааг бэлчээрт хараа хяналтгүй орхих зэргийг тус тус хориглоно.

ТАВ. ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ.

5.1. Тархвар зүйн судалгаанд суурилсан төлөвлөлт

5.1.1. Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч, өвчин гарсан нутгийн малчид, орон нутгийн удирдлагатай хамтран тухайн жил ямааны годрон өвчин гарсан цаг уур, бэлчээрийн нөхцөл зэрэг өвчний дэгдэлт, тархалтад нөлөөлөх хүчин зүйлд оролцооны аргаар тандалт, судалгаа, дүн шинжилгээ хийж, өвчин гарсан шалтгаан, тэмцэх, сэргийлэх ажлын үр дүнгийн талаар дүгнэлт гаргана.

5.1.2. Мал эмнэлгийн тасгийн боловсруулж, Засаг даргаар батлуулсан дараах төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн зардлыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага хянаж, нэгтгэн жил бүрийн 2-р улиралд багтаан аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж шийдвэрлүүлнэ. Үүнд:

- Тархвар зүйн судалгааны дүгнэлтийг үндэслэн боловсруулсан ямааны годрон өвчин гарахаас сэргийлэх, гарсан үед тэмцэх ажлын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал;
- Бүс, нутаг дэвсгэрийнхээ хүрээнд ямааны годрон өвчнөөр тайван эрүүл бүсийг бий болгох хөтөлбөр, төлөвлөгөө;
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх гоц халдварт өвчинтэй тэмцэх төлөвлөгөө;

5.2. Санхүүжилт

5.2.1. “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн холбогдох заалт, Засгийн газраас баталсан “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт”-ын дагуу ямааны годрон өвчинтэй тэмцэх арга хэмжээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Төгсөв.